



“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

2016 оны 06 сарын 15 өдөр

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТӨВ” ТББ-ЫН УДИРДЛАГАД

Бид танай байгууллагын 2015 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын холбогдох олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсхүл алдаанаас хамаарах материаллаг буруу тайлагнал агуулаагүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэж толилуулахтай холбоотой дотоод хяналтын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хүлээх хариуцлага

Хийсэн аудитдаа үндэслэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх нь бидний хариуцлага юм. Бид танай байгууллагын санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, түүнийг Аудитын олон улсын стандарт болон Аудитын дотоод стандартыг баримтлан хийв.

Аудитаар санхүүгийн тайлан дахь тоон мэдээлэл болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахын тулд холбогдох горимуудыг гүйцэтгэсэн болно. Аудитын горимуудыг алдаа эсхүл залилангаас хамаарсан санхүүгийн тайлангийн буруу тайлагналын эрсдэлийн үнэлгээнд суурилан сонгосон. Эрсдэлийн үнэлгээг хийхдээ санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэж толилуулахтай холбоотой үйлчлүүлэгчийн удирдлагын бий болгосон дотоод хяналтыг харгалзан үзсэн бөгөөд тэгэхдээ дотоод хяналтын үр өгөөжийн талаар дүгнэлт гаргах зорилгыг агуулаагүй. Түүнчлэн аудитаар үйлчлүүлэгчийн хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдал болон тооцооллын үндэслэлийг үнэлэв.

Бидний олж авсан аудитын нотолгоо аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Дүгнэлт

Танай байгууллагын 2015 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайланг холбогдох олон улсын стандарт болон эрх бүхий байгууллагаас тогтоосон дүрэм журамд нийцүүлэн, бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна.

Аудиталсан санхүүгийн тайлангийн хураангуйг хавсаргав.



Т.СУГАРСҮРЭН



“NIISLEL-AUDIT” LLC

Certified audit, appraisal and accounting
consultancy company

Date: 2016-06-15

INDEPENDENT AUDITOR’S REPORT

To: Director Naranjargal Khashkhuu
“Globe International Center” NGO

We have audited the accompanying financial statements of “Globe International Center” NGO which comprise statements of financial position as of 31 December 2015, statements of comprehensive income, changes in equity and cash flows for the year then ended and a summary of significant accounting policies and other explanatory notes, respectively.

Management’s Responsibility for the Company Financial Statements

Management is responsible for the preparation and fair presentation of these Company financial statements in accordance with International Financial Reporting Standards, and for such internal control as management determines is necessary to enable the preparation of financial statements that are free from material misstatement, whether due to fraud or error.

Auditor’s Responsibility

Our responsibility is to express an opinion on the Company financial statements based on our audit. We conducted our audit in accordance with International Standards on Auditing. Those Standards require that we comply with ethical requirements and plan and perform the audit to obtain reasonable assurance over whether the financial statements are free from material misstatement.

An audit involves performing procedures to obtain audit evidence about the amounts and disclosures in the Company financial statements. The procedures selected depend on the auditor’s judgment, including the assessment of the risks of material misstatement of the financial statements, whether due to fraud or error. In making those risk assessments, the auditor considers internal controls relevant to the entity’s preparation and fair presentation of the financial statements in order to design audit procedures that are appropriate in the circumstances, but not for the purpose of expressing an opinion on the effectiveness of the entity’s internal control. An audit also includes evaluating the appropriateness of accounting policies used, and the reasonableness of accounting estimates made, by management, as well as evaluating the overall presentation of the financial statements.

We believe that the audit evidence we have obtained is sufficient and appropriate to provide a basis for our audit opinion.

Opinion

In our opinion, the accompanying financial statements present fairly, in all material respects, the financial position of the “Globe International Center” NGO as at 31 December 2015, and their financial performance and their cash flows for the year then ended in accordance with International Financial Reporting Standards.


General Director, CPA
T. SUGARSUREN

